



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠ ᠶ᠋ᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 29 өдөр

Дугаар 1/87

Алтай хот

**Гэрээ байгуулж шууд худалдан
авалт хийх эрх олгох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4 дэх зорилго, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Туульсын хаан Жангар" тууль хайлах үйл ажиллагааны телевизийн шууд дамжуулалт, Малчны хотноос Засаг даргын мэндчилгээ, "Өндөр Алтайн энх мэндийн золголт"-ын 40-50 минутын нэвтрүүлэг, Галын тахилга, "Туульсын өлгий Алтай" эрдэм шинжилгээний бага хурлыг нэвтрүүлэх ажлыг "Суваг Ти ви Найм" ХХК-тай гэрээ байгуулан мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл хийх ажлыг Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас шууд худалдан авах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу уг ажлыг чанартай гүйцэтгүүлэн гэрээний хэрэгжилтийг хангуулж дүгнэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Нийгмийн бодлогын хэлтэс(С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР